



Bayangol Hotel

Баянгол Зохио Бүүдэл ХК

2021

ОНЫ ТАЙЛАН

Компанийн тухай



Регистрийн
дугаар

2026899



Үйл
ажиллагааны
чиглэл

Зочид Буудал
Зоогийн газар



Компанийн
хаяг

Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө



Хувьцаа
ЭЗЭМШИГЧИЙН
ТОО

1122 хувьцаа
ЭЗЭМШИГЧИДТЭЙ



Баянгол Зочид
Буудал ХК-нь 1964
онд анх
байгуулагдсан.



1991 онд хувьцаат
компани болж
хувийн хэвшлийн
аж ахуйн нэгж
болон
өөрчлөгдсөн.



2003 онд 4 одны
зэрэглэл авсан
Үндэсний 100% ийн
хөрөнгө
оруулалттай зочид
буудал юм.



2019 онд
ISO9001:2015
стандартыг нэвтрүүлэгч
дотоодын анхны зочид
буудал болсон.



360 орчим зочин
хүлээн авах, таван
ангилалын 205
өрөөтэй.



300-400 хүн зэрэг
хүлээн авах "Баянгол
ресторан".
Үндэсний хоолоор
үйлчлэх "Монголын нэг
өдөр ресторан".
Дээд зэрэглэлийн
виноны "Wine
House" Ресторан.



Зочны угаалга,
ерөөний үйлчилгээ,
үсчин гоо сайхан,
саун, фитнес
интернет зэрэг 20
гаруй төрлийн
дагалдах үйлчилгээг
зочдод үзүүлж байна.

Эрхэм зорилго

Баянгол зочид буудал хувьцаат компани нь зочдоо дээдэлсэн, зочин бүртээ чин сэтгэлээсээ үйлчилдэг байгууллага.

Алсын хараа

“Баянгол зочид буудал” хувьцаат компани нь зочлохуйн үйлчилгээний салбарт тэргүүлэх чиглэл баримтлан, гадаад дотоодын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, чадварлаг мэргэжлийн баг хамт олныг бүрдүүлэн орчин үеийн дэвшилтэт технологиудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн олон улсын үйлчилгээний стандарт болон үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжид нийцсэн “Баянгол брэнд”-ийн үйлчилгээг буй болгоно.

Зорилт



Зочид гийчдийн ая тухтай орчныг бүрдүүлэх хөрөнгө оруулалт хийх.



Туршлагатай мэргэшсэн ажилчдыг бэлдэх.



Буудлын ор ашиглалтыг бууруулахгүйгээр, борлуулалтын нийт орлогыг өмнөх жилээсээ тогтмол өсгөх.

Компанийн бизнесийн үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл

Дэлхий нийтийг хамарсан цар тахалаас улмаас 2020-2021 онуудад аялал жуулчлал зочид буудлын үйл ажиллагаа бүрэн зогссон ч манай байгууллага нь ажлын байраа хадгалж үлдэх, ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдэхийг хичээж тогтмол цалинжуулж, албан татваруудаа төлсөөр байна.

2021 онд “Баянгол Зочид Буудал” ХК нь үйл ажиллагаагаа өргөжүүлэн хөрөнгө оруулалт хийж Төв аймгийн Эрдэнэ сум, “Цонжин болдог” дахь морьт хөшөөний зэргэлдээ 5 одны зэрэглэлийн зочид буудлыг “Баянгол Ресорт” нэртэйгээр нээж зочид, амрагчдын ая тухтай байдлыг бүрдүүлж дотоодын аялал жуулчлал, зочид буудлын салбарт шинэ өнгө төрх нэмсэн.

Үйл ажиллагаа өргөжүүлэх талаар

“Баянгол Зочид Буудал” ХК 2020-2021 оныг дамнансан цар тахалын хүнд хэцүү үед үйл ажиллагааг бүрэн зогсч, алдагдалтай ажиллаж байгаа хэдий ч ашиг орлогыг нэмэгдүүлэх, ажлын байраа хадгалах зорилгоор нөөц боломждоо тулгуурлан “Баянгол Ресорт” зочид буудлын төсөлд нийт 7,2 тэрбум төгрөгийн ашиглалтын өмнөх хөрөнгө оруулалтыг хийж улмаар 2021 оны 7 сараас үйл ажиллагаагаа эхлүүлэн амжилттай ажиллаж, цэвэр агаар, эрүүл аюулгүй орчинд дотоодын зочид, аялагчдыг хүлээн авч үйлчилж байна.





BAYANGOL

HOTEL & RESORT

Танилцуулга

Хагас зуун жил Монголын Аялал жуулчлал, зочлох үйлчилгээ, зочид буудал, үйлчилгээний салбарын хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэсээр ирсэн “Баянгол зочид буудал” ХК нь үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж өөрийн салбар тансаг зэрэглэлийн “Bayangol Hotel & Resort”-ыг Улаанбаатар хотоос 57 км зайд Төв аймгийн Цонжин Болдогт шинээр нээлээ.

“Bayangol Hotel & Resort” нь агаарын цэнгэг, байгалийн сайханд зочдынхоо тав тухыг бүрэн хангахуйц 4 ангилалын нийт 34 өрөөтэй.

Баянгол Ресортт төсөлд хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн ажлуудыг дурьдвал:

- Барилгын гадна талбайн их заслын ажил
- Угаалгын иж бүрэн тоног төхөөрөмж нийлүүлж угсрах
- Лифт нийлүүлж угсрах
- Дээврийн иж бүрэн засал
- Цахилгааны хэрэгслэл засвар
- Холбоо дохиолол интернэтийн холболт
- Гал тогооны тоног төхөөрөмж угсралт суурилуулал
- Газын холболт
- Агааржуулалт салхилуулалт
- Бассейн сауны иж бүрэн засвар тохижилт

Уг төсөлд дотоодын ханган нийлүүлэгчдийг дэмжиж хамтран ажилласан байдал

50 гаруй ААН, 10 гаруй хувь хүнээс ажил үйлчилгээ болон бараа материалыг гэрээлэн худалдан авч, хамтран ажилласан нь дотоодын үйлдвэрлэгч, нийлүүлэгч компаниудад цар тахлын үед харилцан дэмжлэг болохын зэрэгцээ эдгээр нийлүүлэгчдээр дамжуулан улсын сан хөмрөгт зохих хувь нэмрээ оруулан татвар төлсөн. Үүнд:


Жигүүр Гранд ХХК
Метро экспресс ХХК
Сигма ХХК
Ти энд жи ХХК
БСБ коммерс
Нэкст

Номин тав
Номин Мишээл ХХК
Мобиком корпораци ХХК
Өнө тэгш арвижих
Тулга техник ХХК
Юнигаз ХХК

Орлого үр дүнгийн талаар

/Баянгол Зочиг Буудал ХК/

Тайлангийн үзүүлэлтээс харахад 2019 он хүртэл үндсэн үйл ажиллагааны орлого тогтвортой байсан бөгөөд 2020 онд Дэлхий нийтийг хамарсан цар тахал /сovid 19/ ын улмаас салбарын эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэн ч хөл хорионоос бусад үед орлогоо нэмэгдүүлж, хэмнэж болох бүх зардлаа хэмнэж ажилласан.




2021 онд 2,9 тэрбум төгрөгийн орлого олж 3,3 тэрбум төгрөгийн зардалтай ажилласан.

Зардлыг бүтцээр нь ангилж үзвэл:

- 46% буюу 1,6 тэрбум нь Цалин, НДШ-ийн зардал,
- 38.73% хувь буюу 1,3 тэрбум нь ББӨ,
- 1.06% хувь 35,7 сая төгрөг ашиглалтын зардал,
- 0.56% буюу 19,1 сая төгрөгийг барилгын урсгал засварын зардал,
- 11.1% буюу 382,5 сая төгрөгийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал,
- 2.2% буюу 74,4 сая төгрөгийг үл хөдлөх хөрөнгийн болон газрын татвар эзэлж байна.

Зардлын бүтэц



2017-2021 он борлуулсан нийт өрөө болон ор хоног ашиглалтын тоо, өрөө ашиглалтын хувь

Он	2017	2018	2019	2020	2021	2022 оны төлөвлөг өө
Нийт ашиглах боломжтой өрөө	78864	78864	78864	76260	76260	74095
Борлуулсан өрөөний тоо	24782	27262	24997	2027	8304	13850
Борлуулсан орны тоо	35674	38578	36270	2702	10127	16425
Өрөө ашиглалтын хувь	31%	35%	32%	2%	11%	19%
Буудлын орлого /тэрбум. төгрөг/ Орлого өсөлт, бууралт /өмнөх оноос/	3,11	3,52	3,28	0,25	1,01	2,28
	-	+13%	-7%	-92%	+302 %	+125%



Улсад төлсөн Татвар,НДШ

“Баянгол Зочид Буудал”ХК нь 2021 траватат нийт дүнгээрээ 375,7 сая төгрөгийг Улсын төвлөрсөн төсөвт төлсөн байна.

	Сая. төгрөг
НХАТ	20,4
ХХОАТ	103,8
ААНОАТ	0,4
Үл хөдлөх хөрөнгийн татвар	50,9
Газрын төлбөр	29,9
Авто тээврийн татвар	0,9
Улсын тэмдэгтийн хураамж	2,8
НДШ	166,6
Нийт	375,7

Гадна зам талбайн тохиожилт, их засварт

2021 онд дараах ажлууд хийгдсэн:

	Сая. төгрөг
Гадна зам талбай, автомашины зогсоолыг сайжрууж асфальтан хучилт хийсэн	77,0
Хэрэглээний халуун усны нацосс сольж шинэчилсэн	30,0
Баянгол Ресторанаас Б буудал руу нэвтрэх хүзүүвч хэсэгт их засвар хийсэн	50,0
	НИЙТ 157.0

Үнэт цаасны мэдээлэл

“Баянгол Зочид Буудал” нь 1964 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 375 тоот тогтоолын дагуу анхны үйлчилгээг эхлүүлж байсан түүхтэй. 1991.12.11-ний өдрийн Засгийн газрын өмч хувьчлалын комиссын 27-р тогтоолоор “Баянгол Зочид Буудал ХК” хувийн хэвшлийн аж ахуй болон өөрчлөгдөж анхны хувь нийлүүлсэн зочид буудал болсон байна.


“Баянгол Зочид Буудал” ХК нь 1991 онд ХК болсноосоо хойш хувьцаа эзэмшигч нарт жил бүр тогтмол ногдол ашиг хувиарлаж байсан бөгөөд энэ хугацаанд нийт 2 тэрбум төгрөгийн ногдол ашиг хувиарласан байна.

Дэлхий дахиныг хамраад байгаа цар тахал, түүнтэй холбогдсон хорио цээрийн дэглэмийн улмаас 2021 онд алдагдалтай ажилласан.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 16-ний өдрийн №01 тоот тогтоолоор 2021 онд ногдол ашиг тараахгүй гэж шийдвэрлэсэн.

Он	Дүрмийн сан /мян.төг/	Нэгж хувьцаанд олгосон ногдол ашиг /төг/	Нэгж хувьцааны зах зээлийн дундаж үнэ	Хувьцааны тоо
2017	54,998.5	355	34300	423065
2018	54,998.5	355	29900	423065
2019	54,998.5	360	27000	423065
2020	54,998.5	-	27900	423065
2021	54,998.5	-	28631	423065

Хувьцааны мэдээлэл



2021.12.31

Нээлтийн ханш:	33,000
Хаалтын ханш:	33,000
Авах дээд үнэ:	33,000
Зарах доод үнэ:	33,000
Арилжигдсан өдөр	129
Нийт гаргасан хувьцаа:	423,065
Арилжигдсан ширхэг	13,404
Арилжааны дүн	383,775,500
Нэгж хувьцааны зах зээлийн дундаж үнэ	28,631

“Баянгол Зочид Буудал” ХК-ийн стратеги төлөвлөгөө 2022 оны компанийн үндсэн зорилго

1. Захиргаа, Хүний нөөцийн алба

Зорилт : Эерэг хандлага, эрүүл ажилтан

- ✓ Хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох
- ✓ Ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
- ✓ Ажиллагсдын сургалт хөгжлийг дэмжих
- ✓ Ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээг хэрэгжүүлэх
- ✓ Ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах
- ✓ Баримт бичгийн нэгдсэн санг удирдан зохион байгуулах

2. Борлуулалт, Маркетингийн алба

Зорилт: Найрсаг харилцаа, тогтвортой харилцагч

- ✓ 2021 оны борлуулалт маркетингийн төлөвлөгөө боловсруулах
- ✓ Буудлын орлогыг нэмэгдүүлэх
- ✓ Өрөө ашиглалтыг нэмэгдүүлэх
- ✓ Гэрээт түнш, харилцагчийн тоог нэмэгдүүлэх
- ✓ Зочид, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, гомдлыг бууруулах
- ✓ Идэвхжүүлэлтийн арга хэмжээний өгөөжийг нэмэгдүүлэх

3. Буудлын үйлчилгээний алба

Зорилт: Харилцааны ур чадвар-үйлчилгээний ажилтан

- ✓ Буудлын зочдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
- ✓ Угаалгын чанартай холбоотой гомдлыг бууруулах
- ✓ Үл тохирлыг бууруулах

4. Хоол үйлдвэрлэл, Үйлчилгээний алба

Зорилт: Зочноо дээдэлж, ажилтнаа дэмжин, зочлох үйлчилгээгээр манлайлагч байх

- ✓ Рестораны орлогыг нэмэгдүүлэх, өртөг зардлыг бууруулах
- ✓ Хоолоор үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх
- ✓ Ресторанаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
- ✓ Ресторанаар үйлчлүүлэгчдийн гомдлыг бууруулах
- ✓ Хоолны нэр, төрөл, чанарыг сайжруулах
- ✓ Хоол үйлдвэрлэлд эрүүл ахуйн зөв дадлыг хэвшүүлэх
- ✓ Үл тохирлыг бууруулах

5. Санхүү, Хангамжийн алба

Зорилт: Үр ашиггүй зардлыг хэмнэж хэвшье

- ✓ 2022 оны бизнес төлөвлөгөө, төсөв бэлтгэх
- ✓ 2021 оны тайлан баланс, татварын тайлангууд гаргах, үр дүнд шинжилгээ хийх, хөндлөнгийн аудит хийлгэх, ХЭХ хуралд бэлтгэх
- ✓ Ханган нийлүүлэгч нарыг дундаж үнэлгээг сайжруулах
- ✓ Дотоод хэрэглэгчдийн гомдлыг бууруулах
- ✓ Орлого, зардлыг нэр төрөл, алба нэгж бүрээр төлөвлөгөөтэй харьцуулсан судалгаа хийж, дүгнэлт хийх, зардлыг зохистой хэмнэх ажил зохион байгуулж, тогтмол болон урсгал зардлын зохистой хэрэглээг бий болгох
- ✓ Татвар, НД-ын хуулийн нийцлийг хангах
- ✓ Авлага, өглөг
- ✓ Хүү, татвар, элэгдэл, хорогдлын зардлыг тооцохын өмнөх ашиг (нийт компанийн хэмжээний)

6. Инженер, Техникийн алба

Зорилт: Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллацгаая

- ✓ Хөрөнгө оруулалт шинэчлэлийн ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх
- ✓ Урсгал засварыг графикийн дагуу хийж, засварт зарцуулах дуудлагын дундаж хугацааг бууруулах
- ✓ Дотоод хэрэглэгчдийн гомдлыг бууруулах

7. Хамгаалалтын алба

Зорилт: Өндөржүүлсэн хяналт, Аюулгүй орчин

- ✓ Зочид үйлчлүүлэгч, ажилчдын аюулгүй байдлыг хангах, хамгаалах
- ✓ Объектын бүрэн бүтэн байдлыг хариуцаж ажиллах
- ✓ Зөрчлийн тоог бууруулах

“Баянгол зочид буудал” ХК-ийн ТУЗ-ийн
2022 оны 03 сарын 17 өдрийн 1 тоот тогтоолын Хавсралт 2

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС ЦАХИМААР САНАЛ ХУРААХ, ШИЙДВЭР ГАРГАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Цахимаар санал хураах ажиллагааг дараах дэс дарааллаар зохион байгуулна. Үүнд:

1. Цахимаар санал хураах тухай ТУЗ-ийн шийдвэр гарч, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлсний дараа буюу 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хүргүүлэх, 2022 оны 03 дугаар сарын 22 болон 4 дүгээр сарын 06-ны өдрүүдэд өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевизээр болон олон нийтийн сүлжээгээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд тогтмол мэдээлэх ажлыг хурал зохион байгуулах комисст хариуцан хэрэгжүүлэх.
2. Шийдвэр гаргахад оролцож санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр буюу 2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдрөөр тасалбар болгон гаргасан нэрсийн жагсаалтыг ҮЦТХТ-өөс хүлээн авсны дараагийн өдрөөс буюу 2022 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 15 цаг хүртэлх хугацаанд компанийн оффист хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн биеийн байцаалтыг санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалттай тулган шалгаж, хувьцаа эзэмшигч мөн болохыг баталгаажуулсны дараа нэрийг нь бүртгэлийн жагсаалтад бүртгэж, шийдвэр гаргахтай холбоотой бүх асуудлыг танилцуулах, санал авах хуудсыг бөглүүлэн авч, битүүмжилсэн хайрцагт хийх ажлыг Санал хураах ажлыг зохион байгуулах комиссын гишүүд хариуцан хэрэгжүүлнэ.
3. Компанийн цахим хаягаар ирсэн саналын хуудсыг Шийдвэр гаргахад оролцож санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр буюу 2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдрөөр тасалбар болгон гаргасан нэрсийн жагсаалтыг ҮЦТХТ-өөс хүлээн авсны дараагийн өдрөөс буюу 2022 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс хойш өдөр бүр бүртгэн авч, жагсаалттай тулган шалгаж санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчээс ирүүлсэн санал мөн бол жагсаалтад бүртгэж, саналын хуудсыг хэвлэн битүүмжилсэн хайрцагт хийж хадгална.
4. Цахим санал хураалтаар шийдвэр гаргахаар тогтоосон өдөр буюу 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 16 цагт Хурал зохион байгуулах комисс, Тооллогын комиссын гишүүд Компанийн төв оффист цуглан битүүмжилсэн хайрцагийг нээх, санал тоолох, тооллогын дүнг гаргах, Тооллогын комиссын тогтоолыг болон хувьцаа эзэмшигчдээс цахимаар санал хураасан дүнгээр тогтоол албажуулан гаргах ажиллагааг ТУЗ-ийн дарга болон гишүүдийн хяналтын дор хэрэгжүүлнэ.
5. Энэхүү ажиллагаанд хяналт тавих хүсэлтэй хувьцаа эзэмшигч оролцох эрхтэй.

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Bayangol Hotel

Баянгол зочид буудал хувьцаат компани нь зочдоо дээдэлсэн, зочин бүртээ чин сэтгэлээсээ үйлчилдэг байгууллага болно.

